

ТАНИЛЦУУЛГА  
ОЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙН ҮНДЭСНИЙ  
ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ

Ойн тогтвортой менежментийн үндэсний хөтөлбөрийн төслийг Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015 он), Гурван тулгуурт хөгжлийн бодлого (2018 он) REDD + Монгол хөтөлбөр (2015 он) -үүдийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын дөрөв дэх хэсэгт заасныг баримтлан хийж гүйцэтгэв.

(i). Монгол орны сэрүүн бүсийн (бореал) ой 13.2 сая га талбай<sup>1</sup> эзэлж байгаагаас байгалийн ойгоор бүрхэгдсэн 10.4 сая га; ургаа нөөцгүй, мод бэлтгэсэн, түймэр, хортон, байгалийн гамшигт өртсөн зэрэг шалтгаанаар доройтсон 1,5 сая га<sup>2</sup> ойн талбай байна. Сэрүүн бүсийн ойн 1 га талбайд 114 шоо метр ургаа нөөц, нийтдээ 1 тэрбум гаруй шоо метр модны нөөц байна. Монгол орны заган ой 4.7 сая га талбайд тархан ургасан байгаас 1.9 га заган ойгоор бүрхэгдсэн, 2.8 сая га нь тармаг (орен) заган ойн талбай байна. Нийт заган ойн<sup>3</sup> 52.1 хувийг улсын тусгай хамгаалалтад авч хамгаалсан ба сүүлийн 20 жилд заган ойн 5.0 хувь нь доройтож, тармаг заган ойн талбай 6.0 хувиар нэмэгджээ.

Монгол орны ойн сангийн өөрчлөлтийн хүчин зүйлсийн урьдчилсан үнэлгээний тайланд<sup>4</sup> дурдсанаар шатсан ойн талбайн 2%, мод бэлтгэсэн талбайн 10.0% орчим нь хомсдолд ордог ба энэ үзүүлэлтээр тооцвол ойгоор бүрхэгдсэн талбай жил бүр дундажаар 47000 га - гаар хорогдож байна.

Бэлтгэж байгаа модныхоо 18.8% - г үйлдвэрлэлийн зориулалтаар, 81.2 %- г түлшний зориулалтаар ашиглаж байна.

Ойн өөрчлөлтийн хамгийн нөлөөтэй хүчин зүйлс болох ойн түймэр, замбараагүй мод бэлтгэл, дараалсан доройтолыг бууруулахад чиглэсэн, ойн зохистой ашиглалтанд суурилсан ойн тогтвортой менежментэд тулгуурласан бодлого, үйл ажиллагаа явуулах нь өнөөдрийн тулгамдсан асуудал болж байна.

Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор одоогийн байдлаар хэрэгжиж байгаа ойн чиглэлийн хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргалаа.

---

<sup>1</sup> Монгол улсын ойн сан -2016 тайлан, Ойн судалгаа, хөгжлийн төв.2017 он

<sup>2</sup> Монгол орны ойн суурь түвшин (2005-2015) тайлан, Монгол орны UN-REDD Үндэсний хөтөлбөр 2018 он

<sup>3</sup> Монгол орны заган ой: Экосистемийн иж бүрдэл, нөөц, экологи-эдийн засгийн үнэ цэнэ. Тайлан, Газар зүй-Геоэкологийн хүрээлэнгийн цөл судалгааны салбар.2018 он

<sup>4</sup> Монгол орны ойн сангийн өөрчлөлтийн хүчин зүйлсийн урьдчилсан үнэлгээ, UN-REDD үндэсний хөтөлбөр, 2017 он.

**(ii). Монгол Улсын Их Хурлын 2015 оны 49 дүгээр тогтоолоор** “Төрөөс ойн талаар баримтлах бодлого” батлагдаж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/98 дугаар тушаалаар “Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний дунд хугацааны төлөвлөгөө”-г батлуулсан байна. Ойг түймэр, хортоноос хамгаалах зэрэг уламжлалт ажлууд хэрэгжиж, ой хамгааллын чадавхи тодорхой хэмжээгээр сайжирч байгаа боловч ойжуулалтыг бүс нутаг бүрээр төвлөрүүлэн гүйцэтгэх, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг нэмэгдүүлэх замаар байгалийн аясаар сэргэн ургасан болон таримал ойг 2021 онд 310.0 мянган га-д хүргэх, далд үндэсний систем бүхий тарьц бойжуулах арга, технологийг эзэмших замаар ойжуулалтын ажлын чанарыг сайжруулж, улирлын хамаарлыг багасгах, агро-ойн аж ахуйн үндэс суурь тавих, бүтээмж сайтай, түргэн ургадаг модыг тарьж ургуулах замаар үйлдвэрлэлийн зориулалттай плантаци байгуулж, ойн тариалан эрхлэх зэрэг эрс шинэчлэлийн агуулагатай шинэ бодлогыг хэрэгжүүлэх талаар дорвитой ажлыг эхлүүлээгүй байна.

**Засгийн газраас 2014 оны 320 дугаар тогтоолоор баталсан** “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг дүгнэж үзэхэд “Нийт 115,2 мянган га ойн талбай цэвэрлэгдэж, ойн төлөв байдал сайжирсан, 115,2 мянган га ойн шатах материалын нөөцийг 2885,8 мянган шоомтрээр тус тус багасган, ойн цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэсэн аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд 6,4 мянган га талбайд ойг нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэсэн, олон үйлдвэрүүд технологио шинэчлэхээр ажиллаж байгаа зэрэг эерэг үр дүнгүүд гарсан байна.

Цаашид шийдвэрлүүлбэл зохих тулгамдаж буй асуудал нь ойн цэвэрлэгээний ажил нь өртөг, зардал өндөртэй нөгөө талаар цэвэрлэх талбайн хэмжээ дэд бүтцээс алслагдсан, ойн зам муутай, гүйцэтгэгч байгууллагын технологийн чадавхи сул, үүний улмаас мод бэлтгэлийн аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлийн оролцоо сул байгаад оршиж байна.

**Засгийн газрын 2005 оны 44 тогтоолоор баталсан** “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж үзэхэд 2005-2015 оны хооронд нийт 40,0 мянган га талбайд ойжуулалт, ойн зурвас, ногоон хэрэмийн ажил гүйцэтгэх байснаас хөтөлбөр хэрэгжсэний дүнд 9676,2 га талбайд зориудаар ойжуулалт, ойн зурвасын ажил хийж гүйцэтгэсэн нь ажлын гүйцэтгэл хангалтгүй байгаа бөгөөд хөрөнгө санхүүжилт хангалтгүй байгаатай холбоотой байна. Хэдийгээр эхний үе шатны ажлын гүйцэтгэл бага хувьтай байгаа боловч ойн зурвас байгуулсан зарим газруудад хөрсний элэгдэл, эвдрэл багасаж, тухайн газар нутагт амьдарч байгаа иргэд ашиг шимийг нь хүртэж байна. Байгалийн задгай ус, усалгаатай хэсгийн ойн зурвасын ургалтын хувь сайн байна. Зарим аймгуудад байгуулсан ойн зурвасаараа өрхийн амжиргааны өртгийг нэмэгдүүлэх, аж ахуй нэгж, байгууллага ашиг олох боломжтой болсон.

Цаашид говь хээрийн бүсэд модлог, сөөглөг, өвслөг ургамал, бүх төрлийн амьтадын бүрдэл, тархац, биомасс, усан хангамж, хөрсний бүтэц, уур амьсгалын зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хамарсан экосистемийн иж бүрэн судалгаа явуулж, ойн зурвасыг байгуулахад хөдөлмөрийг хөнгөвчилсөн орчин үеийн байгальд ээлтэй,

шинэ техник технологи, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, бэлчээрийг усжуулах зорилгоор гаргасан уст цэгүүдийг ашиглан мод үржүүлэг, ойн зурвас бий болгох, эрх бүхий байгууллагуудын салбар хоорондын уялдаа холбоог сайжруулан, зохицуулалтыг хангаж ажиллах зэрэг нь хөтөлбөрийн үр дүнг сайжруулахад чухал ач холбогдолтой болно.

(iii). Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлах тухай УИХ-н 2015 оны 49 дүгээр тогтоолд “2. Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хангах цогц хөтөлбөр боловсруулж, ... зээл тусламжид хамааруулан , ойн нөөцийн удирдлагын оновчтой бүтцийг бий болгох арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай” гэж заасан боловч, өнөөдрийг хүртэл “цогц хөтөлбөр” боловсрогдож, Засгийн газраар батлагдаагүй тулгамдсан асуудал хэвээр байсаар байна.

Төрөөс ойн талаар баримтлах бодлогын нэг дэх хэсэгт “Байгалийн аясаар сэргэн ургаж байгаа болон ойжуулсан талбай 230.5 мянган га байгаа нь ойн нөөцийн хомсдол, доройтлыг бууруулах, нөхөн сэргээх, хамгаалахад чиглэсэн шинэ бодлого боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай харуулж байна” гэж тэмдэглэжээ. Мөн “Бодлогын зорилго, баримтлах зарчим”-ыг тодорхойлсон хоёр дахь хэсэгт “2.1. Монгол орны ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойн хомсдол, доройтлыг зогсоох, ойг нөхөн сэргээх, ойжуулах замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх, зүй зохистой ашиглахад чиглэсэн ойн тогтвортой менежментийг бий болгоход бодлогын зорилго оршино” гэж, 3.2.8 дахь хэсэгт “3.2.8. ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг үе гаттай бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж тус тус тодорхойлсон нь Ойн тогтвортой менежментийн үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх үндэслэл болж байна.

(iv). Гурван тулгуурт хөгжлийн бодлогын 3 дахь хэсэгт заасан “3.1.2.10. “Шинэ хөдөө” төслийг бүсчилж хэрэгжүүлэх арга хэмжээ авах; 3.1.2.11. говийн бүсэд ногоон бүс байгуулах, түүнд түшиглэн өрхийн аж ахуйг хөгжүүлэх “Ногоон морь” төсөл хэрэгжүүлж эхлэх. 3.2.2.1. байгалийн нөөц баялгийг байгаль, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай ашиглах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох; 3.9.2.2. орон нутгийн ажилгүй иргэдийг орлогожуулах хүрээнд зохион байгуулалттай хөдөлмөр эрхлэлтийг дэмжих; 3.9.2.8. жижиг, дунд үйлдвэрлэлийг хөнгөлөлттэй зээл, баталгаа, батлан даалт, санхүүгийн түрээс, даатгалын бодлогоор дэмжих замаар хөдөлмөр эрхлэлт, ажлыг байрыг нэмэгдүүлж, ажлын байр бий болгосон аж ахуй нэгж, ажил олгогчдыг урамшуулах;” зэрэг зорилт, арга хэмжээнүүдийг ойн аж ахуй, мод боловсруулах үйлдвэрийн салбарын онцлогт тохируулан ойн тогтвортой менежментийн үндэсний хөтөлбөрт тусгаж дунд болон урт хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

(v). Дээр дурдсан нөхцөл байдлын шинжилгээний үр дүнг үндэслэн Ойн тогтвортой менежментийн Үндэсний хөтөлбөрийг “ойн доройтлыг бууруулах замаар хүлэмжийн хийн ялгарлыг сааруулах, нүүрстөрөгчийн хуримтлалыг нэмэгдүүлэх,

уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, ойн экосистемийн үйлчилгээг нэмэгдүүлэх” хүрээг хамааруулахаар тодорхойлж байна.

Энэхүү хөтөлбөрийг баталсанаар УИХ-н 2015 оны 49 дүгээр тогтоолын 2-т заасан “2.Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хангах цогц хөтөлбөр боловсруулж..” батлах болон REDD+ хөтөлбөрийн ойн доройтлыг бууруулах, хүлэмжийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх стратеги, үйл ажиллагааны хөтөлбөртнй болох заалтын хэрэгжилт хангагдаж, ойн салбарт олон улсын жишиг, нийтлэг зарчимд нийцсэн бодлого, үйл ажиллагаа явуулах, Гурван тулгуур хөгжлийн бодлогын үндсэн арга хэмжээг дунд хугацаанд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Үр дүнд нь экологийн тэнцвэр, тогтвортой хөгжлийн шаардлагад нийцсэн, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чадавхи бүхий ойн аж ахуйг хөгжүүлэх эхлэл, суурь тавигдана.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Дугаар

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 10.3, Ойн тухай хуулийн 12.1.3, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 49 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Ойн тогтвортой менежментийн үндэсний хөтөлдбөр”-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. “Ойн тогтвортой менежментийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г салбар дундын уялдааг ханган боловсруулж, 2018 оны 12 дугаар сард багтаан батлан хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н. Цэрэнбатад даалгасугай.

3. Ойн тогтвортой менежментийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж, ажиллахыг Сангийн сайд ...Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н. Цэрэнбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, аймаг, нийслэл, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Төрийн худалдан авалтаар авах болон татаас олгож үйлдвэрлэлийг дэмжих мод модон бүтээгдэхүүний жагсаалтыг шинэчлэн батлуулж, мөрдүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзоригт даалгасугай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

У. ХҮРЭЛСҮХ

БАЙГАЛ, ОРЧИН,

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Н. ЦЭРЭНБАТ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,

ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

Б. БАТЗОРИГ

## **ОЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол орны сэрүүн бүсийн (бореал) ой 13.2 сая га талбай<sup>5</sup> эзэлж байгаагаас байгалийн ойгоор бүрхэгдсэн 10.4 сая га; ургаа нөөцгүй, мод бэлтгэсэн, түймэр, хортон, байгалийн гамшигт өртсөн зэрэг шалтгаанаар доройтсон 1,5 сая га<sup>6</sup> ойн талбай байна. Сэрүүн бүсийн ойн 1 га талбайд 114 шоо метр ургаа модны нөөц, нийтдээ 1 тэрбум гаруй шоо метр модны нөөц байна. Монгол орны заган ой 4.7 сая га талбайд тархан ургасан байгаас 1.9 сая га талбай нь заган ойгоор бүрхэгдсэн, 2.8 сая га нь тармаг (орен) заган ой байна. Нийт заган ойн<sup>7</sup> 52.1 хувийг улсын тусгай хамгаалалтад авч хамгаалсан ба сүүлийн 20 жилд заган ойн 5.0 хувь нь доройтож, тармаг заган ойн талбай 6.0 хувиар нэмэгджээ.

Монгол орны ойн сангийн өөрчлөлтийн хүчин зүйлсийн урьдчилсан үнэлгээнд дурдсанаар ойгоор бүрхэгдсэн талбай жил бүр дундажаар 47000 га-р хорогдож байна.

Бэлтгэж байгаа модныхоо 18.8% - г үйлдвэрлэлийн зориулалтаар, 81.2 %- г түлшний зориулалтаар ашиглаж байна.

Ойн өөрчлөлтийн хамгийн нөлөөтэй хүчин зүйлс болох ойн түймэр, замбараагүй мод бэлтгэл, бусад доройтлыг бууруулахад чиглэсэн, ойн зохистой ашиглалтанд суурилсан ойн тогтвортой менежментэд тулгуурласан бодлого, үйл ажиллагаа явуулах нь өнөөдрийн тулгамдсан асуудал болж байна.

Төрөөс ойн талаар баримтлах бодлогын “Бодлогын зорилго, баримтлах зарчим”-ыг тодорхойлсон хоёр дахь хэсэгт “2.1. Монгол орны ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойн хомсдол, доройтлыг зогсоох, ойг нөхөн сэргээх, ойжуулах замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх, зүй зохистой ашиглахад чиглэсэн ойн тогтвортой менежментийг бий болгоход бодлогын зорилго оршино” гэж, 3.2.8 дахь хэсэгт “3.2.8. ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг үе гаттай бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж тус тус тодорхойлсон нь Ойн тогтвортой менежментийн үндэсний хөтөлбөр (цаашид “Үндэсний хөтөлбөр” гэх) - ийг боловсруулж, хэрэгжүүлэх үндэслэл болж байна.

### **Хоёр. Үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилт**

2.1. Үндэсний хөтөлбөрийн зорилго нь ойн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж, ойг хамгаалал, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтын

---

<sup>5</sup> Монгол улсын ойн сан -2016 тайлан, Ойн судалгаа, хөгжлийн төв.2017 он

<sup>6</sup> Монгол орны ойн суурь түвшин (2005-2015) тайлан, Монгол орны UN-REDD Үндэсний хөтөлбөр 2018 он

<sup>7</sup> Монгол орны заган ой: Экосистемийн иж бүрдэл, нөөц, экологи-эдийн засгийн үнэ цэнэ. Тайлан, Газар зүй-Геоэкологийн хүрээлэнгийн цөл судалгааны салбар.2018 он

оновчтой үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын арга хэмжээг тодорхойлж, ойн хомсдол, доройтлыг бууруулах замаар уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ойн экосистемийг бий болгож, иргэдийн амьжиргааг тэтгэдэг, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмждэг, улмаар ногоон ирээдүйд хувь нэмэр оруулдаг ойн салбарыг бий болгоход оршино.

2.2. Үндэсний хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ:

2.2.1. Зорилт 1. Ойн хомсдол, доройтлыг бууруулах үндсэн дээр хүлэмжийн хийн ойгоос ялгаруулах хэмжээг багасгаж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

2.2.2. Зорилт 2. Ойн тогтвортой менежментийн зарчмыг нэвтрүүлж, ойд хуримтлагдах нүүрстөрөгчийн хэмжээг нэмэгдүүлэх;

2.2.3. Зорилт 3. Ойн уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох чадавхийг нэмэгдүүлж, экосистемийн үйлчилгээ, эдийн засгийн үр ашгийг сайжруулах;

2.2.4. Зорилт 4. Ойн менежментийн тогтолцоо, санхүүжилтийн чадавхийг бэхжүүлэх.

### **Гурав. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат**

3.1. Үндэсний хөтөлбөрийг 2018-2025 онд дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.1.1. нэгдүгээр үе шат: 2018-2020 он

3.1.2. хоёрдугаар үе шат: 2021-2024 он

### **Дөрөв. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

4.1. зорилт 1. “Ойн хомсдол, доройтлыг бууруулах замаар хүлэмжийн хийн ойгоос ялгаруулах хэмжээг багасгаж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. ойн аж ахуйн технологийн цогц арга хэмжээ , ойн түмрийн хяналт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар хүний хүчин зүйлсээс үүдэлтэй түймрийн тоо хэмжээг багасгах;

4.1.2. хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын зохион байгуулалт, чадавхийг нэмэгдүүлэх замаар ойн экосистемийн төлөв байдлыг сайжруулах;

4.1.3. хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх зохион байгуулалт, арга технологийг боловсронгуй болгож, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хяналтын чадавхыг бэхжүүлэх.

4.2. Зорилт 2. “Ойн тогтвортой менежментийн зарчмыг нэвтрүүлж, ойд хуримтлагдах нүүрстөрөгчийн хэмжээг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. ойн баялгийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх цогц арга хэмээг хэрэгжүүлэх үндсэн дээр ойн экосистемийн чанарыг сайжруулах;

4.2.2. ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын ажилд шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлж, энэ ажлыг гүйцэтгэх агротехникийн хугацааг уртасган, үр дүнг сайжруулах;

4.2.3. мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх замаар ойн өгөөж, эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг нэмэгдүүлэх.

4.3. Зорилт 3. “Ойн уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох чадавхийг нэмэгдүүлж, экосистемийн үйлчилгээ, эдийн засгийн үр ашгийг сайжруулах” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. Ойн хамгааллыг сайжруулах, дасан зохицох чадавхийг нэмэгдүүлэх замаар экосистемийн үйлчилгээг сайжруулах;

4.3.2. эдийн засгийн хөшүүргүүд бий болгох замаар ой хамгааллыг сайжруулах;

4.3.3. Хуурай бүс нутгийн экосистемийг ойжуулалтын аргаар сайжруулж, цөлжилтийг бууруулах, агро-ойн аж ахуйн загварыг бий болгон хөгжүүлэх.

4.4. Зорилт 4. “Ойн менежментийн тогтолцоо, санхүүжилтийн чадавхийг бэхжүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. чадавхыг бэхжүүлэх, бодлого хэрэгжүүлэх нөхцөл, тогтолцоог сайжруулах;

4.4.2. ойн салбарын санхүүжилтийн тогтвортой механизмыг бий болгох;

4.4.3. үндэсний хөтөлбөрийн менежмент, хэрэгжүүлэх механизм

#### **Тав. Үндэсний хөтөлбөрийн үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт**

5.1. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

5.1.1. Ойгоос ялгаруулах хүлэмжийн хий ...% буурна

5.1.2. Ойн хүлэмжийн хийг шингээх чадавхи ...% нэмэгдэнэ.



5.1.3. Ой модны салбарын үйлдвэрлэл сэргэж, ойн экосистемийн төлбөрийн эрх зүйн орчин бүрдэж, тус салбар өөрөө өөрийгөө санхүүжүүлэх суурь тавигдана.

5.1.4. Ойн экосистемийн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах чадавх нэмэгдэнэ.

5.1.5. Ойн тогтвортой менежмент бий болсоноор ойд суурилсан амьжиргааны эдийн засгийн боломжууд бий болж, хөдөөд үйлдвэрлэл хөгжих нэг чиглэл бий болно.

5.1.6. Олон улсын жишигт нийцсэн ойн мониторингийн систем болон ойн сангийн магадлан итгэмжлэлийн тогтолцоо нэтэрнэ.

5.2. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ 2017 оны жилийн эцсийн үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

N	Шалгуур үзүүлэлт	Нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	
			2017 он	2021.01.01	2025.01.01
1	Ойгоос ялгаруулах хүлэмжийн хий бууралт	тнCO <sub>2</sub> е	5233568.4	Тооцохгүй	
1.1	хүний хүчин зүйлсээс үүдэлтэй ойн түймэрт өртсөн талбайн бууралт	1000га бууралт-%	4 000 000	30.0	70.0
1.2	хөнөөлт шавжид өртсөн ойн талбайн бууралт	1000га		300.0	700.0
1.3	хууль бус мод бэлтгэлийн хэмжээний бууралт	Бууралт-%		10.0	20.0
2	Ойн хүлэмжийн хийг шингээх чадавхийн өсөлт	тнCO <sub>2</sub>	- 67682.8		
2.1	ойн бүтээмжийн (ашиглалт, арчилгаа, цэвэрлэгээ) өсөлт	га/м <sup>3</sup>	114	-	
2.2	Нийт бэлтгэж байгаа модонд эзлэх үйлдвэрлэлийн зориулалттай модны хэмжээ	%	18.2		
2.3	ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хийсэн ойн талбай	1000га		100.0	500.0
		шингээлт	- 67682.8		
3	Ойн салбарт зарцуулж буй төсөв, хөрөнгө	тэрбум₮			
3.1	Улсын төсвөөс зарцуулж хөрөнгө	тэрбум₮			
3.2	Хөрөнгө оруулалт	тэрбум₮	28.0		
3.3	Зээл, тусламж	тэрбум₮			
4	Ойн салбараас оруулж буй хувь нэмэр	ДНБ-д эзлэх%			
4.1	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	тэрбум₮	3.0		

4.2	Үйлдвэрлэж буй мод, модон бүтээгдэхүүний хэмжээ	тэрбум₮	217.0	250.0	500.0
4.3	Мод, модон эдлэл, тавилгын дотоодын хэрэгцээний хангалт	%	45.0	70.0	100.0
4.4	Ойн дагалт баялгаас орох орлого	тэрбум₮			
5	Ойн менежментийн тогтолцооны төгөлдөршил				
5.1	Магадлан итгэмжлэгдсэн ОМБ	тоо	8		
5.2	Магадлан итгэмжлэгдсэн ойн сангийн хэмжээ	Сая.га	0		
5.3	Ойн үрийн аж ахуйн эрх зүйн орчин бүрдсэн байна.	Хууль,	0	1	1
		журмын тоо	1	2	2
5.4	Олон улсын жишигт нийцсэн Үндэсний ойн мониторингийн систем бий болсон байна.	ҮОМС	Байхгүй	ОМСистемийн загвар програм хангамж	ОМС-н ажиллагаа жигдэрсэн байна.
5.5	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем бий болсон байна.	СНСМС	байхгүй	СНСМС-н загвар	СНСМС- н ажиллагаа жигдэрсэн байна.
				Мэдээллийн эх үүсвэрүүд тодорхойлогдоно	

### **Зургаа. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр**

6.1. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

6.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

6.1.2. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

6.1.3. аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө;

6.1.4. банк, санхүүгийн байгууллагын хөнгөлөлттэй зээл;

6.1.5. олог улсын байгаль хамгаалах сангийн санхүүжилт, хөрөнгө оруулалт;

6.1.6.бусад эх үүсвэр.

### **Долоо. Үдэсний хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

7.1. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулах, салбар дундын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн

удирдлагаар хангах, хэрэгжилтэнд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам хариуцан гүйцэтгэнэ.

7.2. Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлтэй холбоотой үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилт нэг бүрийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, техник, технологи, санхүүгийн дэмжлэг үзүүлэх чиг үүргийг Хүнс, хөдөө аж ахуй, ханган үйлдвэрийн яам хариуцан гүйцэтгэнэ.

7.3. Ойн түймэртэй тэмцэх, түймрээс сэргийлэхтэй холбогдсон чиг үүргийг Онцгой байдлын Ерөнхий газар, бүх шатны Засаг дарга хариуцна.

7.4. Ерөнхий чиг үүргийн яамд Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төсөв, хөрөнгө оруулалт, зээл тусламжийн санхүүжилтийг судалж нэмэгдүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх төлөөр оролцогч талуудад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ.

7.5. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь орон нутгийн түвшинд зохион байгуулах, ойн нөөцөд түшиглэсэн жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх, ажлын байр бий болгох чиг, үүргийг бүх шатны Засаг дарга хариуцан гүйцэтгэнэ.

7.6. Ойн мэргэжлийн байгууллага, Ойн нөхөрлөл нь үйл ажиллагаандаа ойн тогтвортой менежментийн зарчмыг мөрдлөг болгож, ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах техник, технологи, инновацыг нэвтрүүлж, ажиллагсаддаа энэ талаарх мэдлэг олгох, мэдээлэл, арга зүйгээр хангах үүрэг хүлээнэ.

### **Найм.Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт- шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө**

8.1. Үндэсний хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран жил бүр хийнэ.

8.2. Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлтэй холбоотой үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилт нэг бүрийн хэрэгжилтийн хяналт- шинжилгээг Хүнс, хөдөө аж ахуй, ханган үйлдвэрийн яам хариуцан гүйцэтгэж, тайлангаа жил бүр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд ирүүлнэ.

8.3. Орон нутгийн хэмжээнд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан жил бүр гүйцэтгэж, тайлангаа Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд ирүүлнэ.

8.4. Үндэсний хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалнуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН

САЙДЫН ТУШААЛ

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх авах хэмжээний

төлөвлөгөө батлах тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7 дэх хэсэг, “Үндэсний хөтөлбөр батлах тухай “ Зөсгийн газрын 2018 оны .... дугаар тогтоолыг тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ойн тогтвортой менежментийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилтийг салбар дундын уялдаатайгаар зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллахыг Ойн бодлого, зохицуулалтын газар /Оюунсанаа/- т даалгасугай.

3. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамааруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлэн хэрэгжүүлж, үр дүнг яаманд тайлагнаж ажиллахыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

САЙД

Н.ЦЭРЭНБАТ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын

2018 оны ...дугаар сарын ...ны өдрийн

А/...дугаар тушаалын хавсралт

## ОЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ

### ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго		Үндэсний хөтөлбөрийн зорилго нь ойн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж, ойг хамгаалал, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтын <u>оновчтой үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын арга хэмжээг тодорхойлж</u> , ойн хомсдол, доройтлыг бууруулах замаар уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ойн экосистемийг бий болгож, иргэдийн амьжиргааг тэтгэдэг, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмждэг, улмаар ногоон ирээдүйд хувь нэмэр оруулдаг ойн салбарыг болгоход оршино.				
Үр нөлөө (Үр нөлөөний шалгуур)						
д/д	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
Зорилт 1. “Ойн хомсдол, доройтлыг бууруулах замаар хүлэмжийн хийн ойгоос ялгаруулах хэмжээг багасгаж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:						
Арга хэмжээ 1. ойн аж ахуйн технологийн цогц арга хэмжээ , ойн түмрийн хяналт болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар хүний хүчин зүйлсээс үүдэлтэй түймрийн тоо хэмжээг багасгах;						
1.1.1	Ойн шатах материалыг багасгах, шороон зурвас байгуулах, эргүүл, хяналтыг сайжруулах зэргээр түймрийн эрсдэлийг бууруулах ойн аж ахуйн арга хэмжээг төсвөөс санхүүжүүлж, тогтмол зохион байгуулна.	1. Улсын хилийн дагуу 2000 км-с багагүй уртааш метр түймрээс хамгаалах зурвас байгуулсан байна.	Түймэрт өртөх ойн талбай багассан байна.	ОБЗГ	СДОА	
		2. Шатах материалыг багасгах зорилтод ойн	Жилд гарах түймрийн тоо буурсан байна. (%)	ОБЗГ	СДОА	

		цэвэрлэгээг .....га талбайд хийсэн байна.			
1.1.2	Ойн нөхөрлөл, нутгийн иргэд, Ойн ангийн гал түймэртэй тэмцэх, сэргийлэх зорилтод сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу явуулж, хэрэгцээт багаж хэрэгслээр хангана.	Ойн түймрээс сэргийлэх, түймэртэй тэмцэх ажлын материаллаг баазыг бэхжүүлж, Улсын тусгай хамгаалалттай газрын захиргаа болон сум дундын ойн ангид ой, хээрийн түймэр унтраах техник, тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах ажлыг санхүүжүүлэх	Түймрийн эрсдлийн бүсэд багтах нутгийн иргэд, ТХГЗ болон Ойн ангиудыг нэр бүхий3-4 төрлийн багаж, хэрэгслээр хангасан байна (Засгийн газрын 2016 оны 106-р тогтоолоор тогтоосон норматив бүрэн хангагдсан байна.	ОБЗГ	СДОА ТХНХЗ
1.1.3	Түймрийг эрт илрүүлэх арга, технологи нэвтрүүлнэ.	Ой бүхий аймаг, сумдад улирлын урамшуулалттай түймрийн эргүүлийг иргэд, ойн нөхөрлөлүүдтэй хамтран сайн дурын бүлэг хэлбэрээр зохион байгуулах замаар түймрийг шуурхай илрүүлэх, урамшуулал үзүүлэх механизм бүрдүүлэх	Түймрийг шуурхай илрүүлсэнээр нэг удаагийн түймэрт ногдох талбайн хэмжээ 50-с доошгүй хувиар буурсан байна .	ОБЗГ	СДОА ТХНХЗ
		Аймгийн БОАЖГ болон Ойн ангиуд зайнаас тандан судлах сансрын мэдээллийг ашиглан түймрийг эрт илрүүлэх технолги эзэмшсэн байна		БОАЖГ	СДОА
Арга хэмжээ 2. Хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын зохион байгуулалт, чадавхи, ойн экосистемийн төлөв байдлыг сайжруулах;					
		хөнөөлт шавжийн олшролын үе, ойд		ОБЗГ	СДОА

1.2.1	Судалгааны хүрээлэнгүүдийн хамтын ажиллагаа хөгжүүлэх, тэдгээрт дэмжлэг үзүүлэх замаар хөнөөлт шавьжийн үр нөлөөг урт хугацаанд тооцох судалгааны чадавхыг бий болгох	нөлөөлөх болон тэмцэл хийх хугацаа хугацаа зэрэг хүчин зүйлсийг тодорхойлох чадавхыг бий болгох	Ойн хортны голомт буурсан байна.	ОБЗГ	СДОА	
		Ойн хөнөөлт шавжийн хэт олшролын хөдлөл зүйд ажиглалт судалгаа явуулах мониторингийн суурин цэгүүдийг байгуулсан байх				
1.2.2	Хөнөөлт шавжийн тэмцэлд зарцуулж буй төсвийг үр ашигтайгаар зарцуулж буйг баталгаажуулах чадавхтай ойн эрсдэлийн-үзүүлэлт бүхий системийг боловсруулах	Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд дотоодын биобэлдмэлийн үйлдвэрүүдийг дэмжиж ажиллах	Нэгж талбайд ногдох хортон устгалын зардал буурсан байна.	ОБЗГ	СДОА	
1.2.3	Ойн хөнөөлт шавьжид тэсвэртэй байх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хөнөөлт шавьжийн нэгдсэн менежмент болон ойн тогтвортой менежментийн стратегиудын талаарх мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаанууд, чадавхыг бэхжүүлэх сургалтуудыг зохион байгуулах	олон нийт болон шийдвэр гаргагчдад зориулсан мэдлэг, мэдээллийг бий болгох хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх	Сургалтын 3 төрлийн модуль бий болж, сургалтууд зохион байгуулагдаж хэвшсэн байна.	ОБЗГ	СДОА	
		Ойн мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх		ОБЗГ	ТЗУГ	
		МСҮТ, Ойн нөхөрлөлд зориулсан сургалтын хөтөлбөр		ОБЗГ	ТЗУГ	
1.2.4	Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажлын хүрээнд тусгай биоконтролуудыг вирус хэлбэрээр ашиглах, Ж нь Nucleopolyhedrosis вирус.	Ойн хөнөөлт шавжид шимэгч болон ангуулчилдаг зүйлийг илрүүлэх судалгаа хийх, тэдгээрийг лабораторийн нөхцөлд үржүүлэх	Ойн хортны ангуучид, шимэгчдийг үржүүлэх лаборатори байгуулагдсан байна.	ОБЗГ	ОСХТ	

1.2.5	Ой модыг эрүүлжүүлж, хөнөөлт шавжид тэсвэртэй ойг бий болгох,	Ойн хортны голомт бүхий ойд АЦО хийгдсэн	Ойн хортны тархалт хязгаарлагдсан байна.	ОБЗГ	СДОА	
Арга хэмжээ 3. Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх зохион байгуулалт, арга технологийг боловсронгуй болгож, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хяналтын чадавхыг бэхжүүлэх.						
1.3.1	Санкт-Петербургийн тунхагийг хэрэгжүүлж хууль бус мод бэлтгэхтэй тэмцэх арга хэлбэрийг боловсронгуй болгох замаар хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх	Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийг мөрдөн шалгах, мэдээлийн нууцыг хадгалах болон сум дундын ойн ангиудын ойн эргүүл хийх чадавхыг бэхжүүлэх	Хууль бусаар мод бэлтгэх зөрчил буурсан байна.	ОБЗГ	СДОА	
		Ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүдийн ойн эзэмшлийн эрхийг боловсронгуй болгож, ойг эзэнтэй болгох замаар ойн бүсийн хамгааллыг сайжруулах	Эзэмшилд өгсөн ойн сангийн талбайн хэмжээ нэмэгдсэн байна.	ОБЗГ	СДОА	
		Ойн менежмент бүхий нутгаас хууль ёсоор бэлтгэсэн мод нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, Монгол дахь хууль бус мод бэлтгэлийн эрэлт хэрэгцээг хангахын тулд унанги мод бэлтгэх хэмжээг нэмэгдүүлэх	Ойгоос бэлтгэж буй модны хэмжээний өсөлт	ОБЗГ	СДОА	
1.3.2	Орон нутгийн иргэд ойн эргүүлд оролцох, хууль бус үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнахад олгох урамшууллыг	Урамшууллын шинэ журам тогтсон байна.	Урамшуулал авсан иргэдийн хэмжээний өсөлт	ОБЗГ	СДОА	



	нэмэгдүүлэх бодлого боловсруулах					
1.3.3	Хууль бус мод бэлтгэлийн талаар мэдээлэл авах гар утасны программ турших, SMART програм хангамж ашиглах	Зөрчлийн мэдээлэл авах онлайн систем бий болсон байна.	Онлайн сиситемээр авсан зөрчлийн мэдээллийн тоо	ОБЗГ	СДОА	
1.3.4	Ойн мэргэжлийн байгууллагуудын мод бэлтгэлийн хэмжээнд тавих хяналтыг сайжруулах	Ойгоос бэлтгэх модны захиалга авах, борлуулах үйл ажиллагаа Ойн анги хариуцдаг шинэ журам тогтсон байна.	Нийтийн зах зээлд Ойн ангиас нийлүүлсэн модны хэмжээний өсөлт	ОБЗГ	СДОА	
<b>Зорилт 2. “Ойн тогтвортой менежментийн зарчмыг нэвтрүүлж, ойд хуримтлагдах нүүрстөрөгчийн хэмжээг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:</b>						
<b>Арга хэмжээ 4. ойн баялгийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх цогц арга хэмээг хэрэгжүүлэх үндсэн дээр ойн экосистемийн чанарыг сайжруулах;</b>						
2.1.1	Ойн мэргэжлийн байгууллагын техник, технологийн чадавхыг бэхжүүлэх	Техник, технологийг шинэчлэхэд зориулагдсан хөрөнгө оруулалт хийгдсэн байна.	Ойн аж ахуйн технологийн түвшин дээшилж, хүчин чадал нэмэгдсэн	ОБЗГ	ХХААХҮЯ	
		Ойн аж ахуйн мэргэжилтэй ажилтан бэлтгэдэг тогтолцоо бүрдсэн байна. Ой бүхий аймгуудын МСҮТ-д ойн ажилтан бэлтгэх анги нээж, сургалт явуулах	Ойн мэргэжлийн байгууллагын ажиллагсадын мэргэжилтэй ажилтны хангамж нэмэгдсэн байна.	ОБЗГ	ТЗУГ	
2.1.2	Ойн нөөцийг тогтвортой ашиглах, ойн төлөв байдлыг сайжруулах “Цэвэр ой” урт хугацааны төсөл боловсруулж, хэрэгжүүлэх	1. Ойн менежментийн төлөвлөгөөний дагуу ойн нөөцийг ашигладаг журамд шилжсэн байна.	1. Нийт 315.0 мянган га хүртэлх ойн талбай цэвэрлэгдэж, ойн төлөв байдал сайжирна.	ОБЗГ	ХХААХҮЯ	
		2. Мод бэлтгэл, ойн цэвэрлэгээ-мод үржүүлэг, үрийн аж ахуй-мод боловсруулах	2. Ойн шатах материалын нөөцийг жилд 1,4 орчим сая шооометрээр багасгана. 3. 1 га талбай дахь ойн нөөц нэмэгдсэн байна	ОБЗГ	ХХААХҮЯ	

		<p>үйлдвэрлэлийн ойн аж ахуйн кластерыг бүсчлэн байгуулах</p> <p>3. Ой бүхий сумдад “Ойн нөхөрлөл дундын нэгдсэн үйлдвэрлэл-үйлчилгээний төв байгуулах</p>		ОБЗГ	СДОА	
2.1.3	Ойн тогтвортой менежментийг магадлан итгэмжлэхэд шаардлагатай эрх зүйн орчин бүрдүүлж, бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх.	Магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлэх чиглэлээр Ойн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, ойн магадлан итгэмжлэлийн журам гарсан байна.	Магадлан итгэмжлэгдсэн ойн сан болон ОМБ-н тоо нэмэгдсэн байна.	ОБЗГ	ХЗХ	
2.1.4	Ойн болон бусад бүх төрлийн нөхөрлөлүүдэд зориулсан нөөц ашиглах эрхийг нь, нэмэгдүүлэхийг дэмжсэн хууль эрх зүйн орчны тогтолцоог боловсруулж, хэрэгжүүлэх	1. Ойн тухай хуульд “ойн баялгийг давуу эрхээр ашиглах” чиглэлээр нэмэлт оруулж холбогдох журмууд шинэчлэгдсэн байна.	Байгалийн нөөц ашиглах нөхөрлөлийн орлого нэмэгдсэн байна.	ОБЗГ	ХЗХ	
		2. Ойн дагалт баялаг бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх нөхөрлөлийн онцлогт тохирсон арга, технологийг нэвтрүүлэх		ОБЗГ	СДОА	
2.1.5	Ойг тогтвортойгоор ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх менежментийн үйл ажиллагааг дэмжих ойн төв замын сүлжээг сэргээн байгуулах	Монгол орны ойн замын сүлжээний нягтралын судалгаа хийж, эхний ээлжинд барих замын маршрутыг товлох	Судалгааны тайлан	ХХААХҮЯ	ОБЗГ	
		Ойн ашиглалтын нөөцөд тулгуурлан ертөг зардлын тооцоог	Төлөвлөлтийн тайлан	ХХААХҮЯ	ОБЗГ	

		хийж, мод тээврийн замын сүлжээг төлөвлөх				
		Ойн төв замын сүлжээг сэргээн байгуулах (4-МТ зэрэглэл буюу 140 000 м <sup>3</sup> хүртэл мод тээвэрлэх)	100 км ойн төв зам баригдсан байна. (Замын сүлжээний уртын 10%)	ХХААХҮЯ	ОБЗГ	
Арга хэмжээ 5: Ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын ажилд шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлж, энэ ажлыг гүйцэтгэх агротехникийн хугацааг уртасган, үр дүнг сайжруулах;						
2.2.1	Ойд мал бэлчээх бүсүүдийг тогтоож, ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хийх стратеги, техникийн удирдамжуудыг боловсруулж мөрдүүлэх	Ойн нөхөн сэргэлтийг дэмжих зорилгоор мал бэлчээрлэлтийг хязгаарлах эрх зүйн орчин бий болсон байна.	Байгалийн аясаараа нөхөн сэргэсэн ойн талбайн хэмжээ нэмэгдсэн байна.	БОАЖЯ	ХХААХҮЯ	
2.2.2.	Ойн мэргэжлийн аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлүүдэд зориулсан ойжуулалт, нөхөн сэргээлт хийх технологийн чиглэлээр чадавх бэхжүүлэх.	1. Далд үндэсний системтэй тарьц, суулгац ургуулах, тэдгээрээр ойжуулах технологийг нэвтрүүлнэ.	1. Ойгоор бүрхэгдсэн талбай 310,0 мянган га-р нэмэгдсэн байна. 2. Ойжуулалт хийх агротехникийн хугацаа уртассан байна. 3. Байгалийн сэргэн ургалт нэмэгдсэн байна.	ОБЗГ	ЦТХОХ	
		2. Байгалийн сэргэн ургалтыг дэмжин тэтгэх шинэ арга технологийг боловсруулж, нэвтрүүлнэ.		ОБЗГ	ЦТХОХ	
		3. Ойжуулалтын ажлын зардлыг нэмэгдүүлэх, ба үр дүнд суурилсан урамшуулалын системийг бий болгох		ОБЗГ	НХБСТГ	
		4. Орон нутагт ойжуулалтын талбайг сонгохдоо нутгийн иргэд, малчидтай зөвшилцөн зохион байгуулдаг тогтолцоо бий болгох .		ОБЗГ		

2.2.3	Дал үндэсний системтэй /бортогтой/ тарьц ургуулах технологийг боловсруулж, бэлтгэхэд хувийн хэвшил, мод үржүүлгийн газруудад дэмжлэг үзүүлэх	Тарьц ургуулах бортого үйлдвэрлэх үйлдвэр байгуулна	Далд үндэсний систем бүхий тарьц бойжуулах хүчин чадлыг 20.000 000 ш/жил –д хүргэнэ	ОБЗГ	ЦТХОХ	
		Бортогонд тарьц ургуулахад шаардлагатай хөрсний судалгаа явуулж, хөрс бэлтгэж, хэрэгцээг хангах нөхцлийг бий болгох	Хөрс бэлтгэх хүчин чадлыг 20.000 000 ш/жил –д хүргэнэ	ОБЗГ	ЦТХОХ	

**Арга хэмжээ 6. Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх замаар ойн өгөөж, эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг нэмэгдүүлэх**

2.3.1	Ой мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төрийн эдийн засгийн бодлого, зохицуулалт, хууль, эрх зүй, дүрэм, журмын зохицуулалтыг сайржуулах	Ойн цэвэрлэгээгээр хатсан мод, унанги бэлтгэж ашигласан тохиолдолд татаас олгох,	Ойн цэвэрлэгээгээр бэлтгэсэн модны ашиглалтын түвшинг 70%-д хүргэнэ	ХХААХҮЯ	БОАЖЯ	
		Ой модны үйлдвэрлэлийн болон хоёрдогч түүхий эд боловсруулах тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-с чөлөөлөх				
2.3.2	Ой мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дэд бүтэц бүхий кластер болон цогцолборыг байгуулах	Ой бүхий 7 аймагт Ойн аж ахуй, модны кластер үйлдвэр байгуулна,	Хөвсгөл 4ш, ой бүхий аймагт тур бүр 1ш	ХХААХҮЯ	БОАЖЯ	
2.3.3	Техник технологийн хүртээмж, суурилагдсан материаллаг бааз, хүчин чадлын ашиглалт, барилга тоног төхөөрөмжийн хүрэлцээ, чанарыг нэмэгдүүлэх	Нэмүү өртөг шингэсэн шинэ нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл олон зориулалт бүхий технологийн цавчдас үйлдвэрлэнэ	Ой бүхий 7 аймаг 35 технологи цавчдасны үйлдвэр байгуулна	ХХААХҮЯ	БОАЖЯ	
		Шахмал хавтан, МДП, ДСП, WPC8 OSB төрөл бүрийн шахмал түлш, брикет, хорголжин түлш /pellet/ барилгын модон блокын үйлдвэр байгуулах, дэмжлэг үзүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>• үйлдвэр хавтан, board, ДСП, WPC, хөвсгөл/зүүнхараа/</li> <li>• аймаг бүрт шахмал үлшний үйлдвэр</li> </ul>	ХХААХҮЯ	БОАЖЯ	

**Зорилт 3. Ойн уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох чадавхийг нэмэгдүүлж, экосистемийн үйлчилгээ, эдийн засгийн үр ашгийг сайжруулах;**

**Арга хэмжээ 7. Ойн хамгааллыг сайжруулах, дасан зохицох чадавхийг нэмэгдүүлэх замаар экосистемийн үйлчилгээг сайжруулах**

3.1.1	Экологийн чухал бус нутаг, корридуудыг тодорхойлох, ялангуяа усны хагалбар газрууд болон эмзэг бүсүүдийг тодорхойлж, ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх зайлшгүй шаардлагатай завсрын бүсүүдийг тогтоох	Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах	Тусгай хамгаалалттай газрын дэглэмээр хамгаалагдаж байгаа ойн сангийн талбай нэмэгдсэн байна.	ТХНУГ	ОБЗГ	
3.1.2	Хамтын менежментэд суурилсан хамгаалалтыг хэрэгжүүлэх, ялангуяа экологийн чухал бүс нутгууд, тусгай хамгаалалттай газар нутаг болон завсрын бүсүүдэд хамтын менежментийг сайжруулах,	Тусгай хамгаалалттай газар нутагт ойн нөхөрлөл байгуулах эрх зүйн орчинг сайжруулах	Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулдаг Ойн нөхөрлөлийн тоо нэмэгдсэн байна	ОБЗГ	ТХНУГ	
3.1.3	Генетикийн хувьд ой ургамалжилын бүсэд тохирох нь баталгаажсан үрийн аж ахуй эрхэлж, ойн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх.	1. Монгол орны ойн үрийн мужлалыг нарийвчлан тогтоож, мөрдөнө	1. Монгол орны ойн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхи нэмэгдсэн байна. 2. Ой ургамалжилын 3 бүс 9 хошуунд тохирох байгалийн сэргэн ургалтыг дэмжих арга, технолги боловсруулж мөрдүүлнэ	ОБЗГ	ШУА БСШСЯ	
		2. Модлог ургамлын үр, үржлийн материалын тухай хууль гаргана.		ОБЗГ	ХЗХ	
		3. Экосистемийн үйлчилгээний өндөр ач холбодолтой газрууд болон доройтолд орсон ой бүхий бүс нутгуудад унаган модны зүйлүүдийг тарих, ойжуулах, байгалийн аясаар нь нөхөн сэргээх зорилтод төсөл хэрэгжүүлэх		ОБЗГ	Аймаг, нийслэлийн БОАЖГ, Ойн анги	

**Арга хэмжээ 8. Эдийн засгийн хөшүүргүүд бий болгох замаар ой хамгааллыг сайжруулах**

3.2.1	Ойн экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг бодитоор тооцох, үр нөлөөг нэмэгдүүлэх	Ойн экосистемийн үйлчилгээг тооцсон ойн экологи-эдийн засгийн үнэлгээний аргачлал	Ойгоос орох орлого нэмэгдсэн байна.	ОБЗГ	НХБСТГ	
-------	---	---	-------------------------------------	------	--------	--

		боловсруулж, мөрдөж эхэлсэн байна.				
3.2.2	Орон нутгийн иргэдийн ойн дагалт бүтээгдэхүүн боловсруулах, ойн аялал жуулчлал, түлш, бага оврын тавилга, гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, өртгийн сүлжээ бий болгох, тэдгээрт чиглэсэн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Ажил олгогчдод зориулсан Нөлөөллийн хөрөнгө оруулалтын санг байгуулах зорилгоор хувийн хэвшил/банкны сан, хөрөнгө оруулалтын чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлэх	Хөрөнгө оруулалт, ажлын байр нэмэгдсэн байна.	НХБСТГ	ОБЗГ	
3.2.3	Төр болон хувийн хэвшлийн салбарын аж ахуй нэгжүүдэд модны биомассын энерги, модны нүүрс, мод пеллет болон өөр бусад шийдлүүдийн чиглэлээр техникийн тусламж үзүүлэх	Техник, тоног төхөөрөмж, технологиор хангах	Үйлдвэрлэл нэмэгдсэн байна.	ОБЗГ	НХБСТГ	
<b>Арга хэмжээ 9: Хуурай бүс нутгийн экосистемийг ойжуулалтын аргаар сайжруулах, цөлжилтийг бууруулах зорилгоор агро - ойн аж ахуйн загварыг бий болгон хөгжүүлэх</b>						
3.3.1	Заган ойн менежментийг сайжруулж, заган ойн байгалийн нөхөн сэргээлтийг сайжруулах	Заган ойн талбайн нөхөн сэргээх төсөл хэрэгжүүлэх	Заган ойн талбай 1000 га-гаар нэмэгдсэн байна	ОБЗГ	СДОА	
3.3.2	Цөлжилт бүхий бүс нутагт Засгийн газрын “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх	Бэлчээр болон тариалангийн талбай, элсний нүүлтээс хамгаалах хамгаалалтын ойн зурвас байгуулах	“Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд ....га хамгаалалтын ойн зурвас байгуулна.	ОБЗГ	СДОА	
3.3.4	Баян бүрд, усны ундаргуудыг ойжуулалтын аргаар хамгаалах	Говийн баян бүрдийг сэргээх хамгаалах, ойжуулах зорилгод төсөл хэрэгжүүлнэ.	10- с доошгүй доройтолд орсон баян бүрдийг сэргээсэн байна.	ОБЗГ	СДОА	
<b>Зорилт 4. Ойн менежментийн тогтолцоо, санхүүжилтийн чадавхийг бэхжүүлэх.</b>						
<b>Арга хэмжээ 10. Чадавхыг бэхжүүлэх, бодлого хэрэгжүүлэх нөхцөл, тогтолцоог сайжруулах</b>						
4.1.1	Ой мод, модон бүтээгдэхүүнийн салбарын институцийн удирдлага, тогтолцоо, зохион байгуулалт, чиг үүрэг, төр, төрийн бус байгууллагуудын уялдааг хангах	Ой модны салбарын нэгдсэн бодлого удирдлагыг зохицуулах чиг үүрэг бүхий агентлаг байгуулах	Ой, модны агентлаг байгуулагдсан байна	БОАЖЯ	ХХААХҮЯ	2021
		Ой модны салбарын менежмент инноваци,		БОАЖЯ	ХХААХҮЯ	2019

		үйлдвэрлэлийн судалгаа шижнилгээний үндэсний хүрээлэн байгуулна	Ой, модны эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулагдсан байна			
4.1.2	Шийдвэр гаргагчдын болон ойн мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөр гарган хэрэгжүүлэх	Давтан сургалтын модуль, хөтөлбөр	Сургалтанд хамрагдсан мэргэжилтэн, ажилчдын тоо	ТЗУГ	ОБЗГ	
4.1.3	Ойн Судалгаа Хөгжлийн Төвийн чадавхийг нэмэгдүүлэх	(i). Газар зүйн мэдээлэл - ойн мониторингийн лаборатори (ii). Ойн ангууч шавж болон шимэгч шавжийн лаборатори байгуулагдсан байх	Хоёр лаборатори байгуулагдсан байх	ОБЗГ	ОСХТ	
<b>Арга хэмжээ 11. Ойн салбарын санхүүжилтийн тогтвортой механизмыг бий болгох</b>						
4.2.1	Ногоон ДНБ-ий үнэ цэнийг Үндэсний стратеги, бодлогуудад нэгтгэн шингээх замаар ой нь тогтвортой хөгжилд хүрэхэд ямар өндөр ач холбогдолтойг дээд түвшний шийдвэр гаргагчдад сурталчлан ойлгуулах, холбогдох санхүүжилтууд дээр дэмжлэг авах			НХБТГ	ОБЗГ	
4.2.2	Ой мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн санхүүжилтийн асуудал, хөрөнгө оруулалт, банкны зээлийн үйлчилгээг сайжруулах	Мод, модон бүтээгдэхүүн төрийн болон ОНӨ, төрийн өмчит ААН-н худалдан авалтаар дэмжих	Мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэн байна	ХХААХҮЯ	Сангийн яам	
		Ой модны хөрөнгө оруулалтын сан байгуулагдсан байна.		ХХААХҮЯ	БОАЖЯ	
4.2.3	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах донорын санхүүжилтийг олон улсын байгууллага болон хувийн хэвшлийн салбараар дамжуулан эргэлтэд оруулах	Төсөл, хөтөлбөр хэрэгжсэн байна.	Ой менежмент сайжирсан байна.	ОБЗГ	УАӨГХГ	
<b>Арга хэмжээ 12. Үндэсний хөтөлбөрийн менежмент, хэрэгжүүлэх механизм</b>						
4.3.1	Талуудын оролцоо болон нийгмийн бүлгүүдийн тэгш оролцооны чадавхыг хангах	1. REDD+-ийн өргөтгөсөн (дээд түвшний) ажлын хэсгийн		ОБЗГ	СДОА	

		үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх 2. Иргэний нийгмийн форумын үйл ажиллагааг тогтмолжуулах,				
4.3.2	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангаж сайжруулах	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем	СНСМС-н үйл ажиллагаа тогтмолжсон байна	ОБЗГ	ОСХТ	
4.3.3	Ойн мониторингийн Үндэсний Системийн үйл ажиллагаа хэвийн үйл ажиллагааг хангаж , сайжруулах	ОСХТөвд Ойн мониторингийн лаборатори байгуулна	REDD+-ийн Үндэсний ойн мониторингийн системтэй болсон байна.	ОБЗГ	ОСХТ	
		Тоног төхөөрөмж, програм хангамжийг сайжруулах		ОБЗГ	ОСХТ	
4.3.4	Ойн суурь түвшнийг тогтмол шинэчлэх ажил хийгдэж байх			ОБЗГ	ОСХТ	
4.3.4	Ойн менежментийн төлөвлөгөөг улс, аймаг, нийслэл, тусгай хамгаалалттай газар, гэрээгээр эзэмшсэн аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлийн түвшинд шинэчлэн боловсруулж, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлдэг тогтолцоонд шилжих	Ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх анхан шатны байгууллага-ойн ангийн мэргэжлийн болон техникийн чадавхийг сайжруулах, нэмэгдүүлэх		ОБЗГ	ОСХТ	
4.3.5	Ойн магадлан итгэмжлэлийн тогтолцоо, мөнгөн бус урамшууллын механизмыг бий болгох	Ойн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Ойн магадлан итгэмжлэл явуулах журмын төсөл боловсруулж, шийдвэрлүүлэх замаар ойн магадлан итгэмжлэлийн эрх зүйн орчныг бий болгох		ОБЗГ	ХЗХ	



